

Түүх 4 : Загасчин залуу

Библийн эшлэл
[Матай 4:19]

Есүс тэдэнд – Намайг дага, Би та нарыг хүмүүсийн загасчид болгоно гэв.

Нэгэн өдөр Есүс Галил нуур руу явав. Тэгэхэд тэнд загасчин ах дүү Петр болон Андрей нар загасчилж байв. Шөнөжингөө загасчлаад ганц ч загас барьж чадаагүй Петр болон Андрей нар нуурын эрэг дээр завиа гаргаж ирээд загасны тороо угааж байв. Тэднийг тороо угааж байх үед нь Есүс хүрч ирэв.

Мөн олон түмэн Есүсийг дагасаар л байв.

Харин Есүс Петрийн завин дээр гарсны дараа хүмүүст тэнгэр улсын сайн мэдээг зааж байлаа.

Тэрээр ярьж дуусаад Петрд ийнхүү айлдав. “Усны гүн рүү яв. Тэгээд тороо шидэж загас барь!” гэж хэлэв.

Петр болон Андрей нар мэргэжлийн загасчид байлаа.

Гэхдээ шөнөжингөө загасчлаад ганц ч загас барьж чадаагүй байхад Есүс тороо нуурт хая гэсэн юм.

Гэтэл Петр Андрей хоёр Есүсийг шоглох бус Түүний үгэнд орж тороо хаяв.

Петр Андрей хоёр болж байгаа явдалд гайхширч орхив.

Учир нь тэдний шидсэн тор загасаар дүүрч орхив

Бүр тор урагдах хэмжээгээр их болсон байлаа. Энэ гайхамшигт явдлыг ойрхноос харж байсан ах дүү Иаков,

Иохан хоёр Есүсийн өмнө сөхрөн унав. Есүс тэдэнд ингэж айлдав.

“Бүү айгтун. Чи одоо загас барьдаг загасчин бус хүмүүсийг авралд хүргэх загасчин болох болно” гэв.

Тэд бүгд завиа орхиж Есүсийг дагав.

Ингээд Петр, Андрей, Иаков, Иохан нар Есүсийн шавь нар болсон юм.

Нэгэн өдөр Есүс Матай гэх хүнтэй уулзав. Матай бол татвар хураагч нэгэн байлаа.

Тухайн үед маш их хэмжээний татвар хураадаг байсан учраас түүнийг хүмүүс ихэд ад үздэг байв.





Ийнхүү хүмүүс, Матайг нүгэлтэн мэт үзэж, үзэн ядагддаг байв. Гэвч Есүс түүнд ойртон очоод ингэж айлдав.

“Намайг дага” гэж хэлэв.

Харин Матай энэ үгийг сонсмогцоо бүх зүйлээ орхиод Есүсийг дагаж Түүний шавь болсон юм.

Есүсийг Матайн гэрт олон татвар хураагчидтай хамт хооллож байхыг харсан Фарисайчууд ихэд дургүйлхэж байв.

Энэ үед Есүс ийнхүү айлдав. “Эрүүл хүнд эмч хэрэггүй харин өвчтэй нэгэнд эмч хүн зайлшгүй хэрэгтэй.

Би зөвт нэгний төлөө энэ дэлхийд ирсэн бус харин гэмтэй хүмүүсийн төлөө ирсэн билээ.

Тиймээс ч эдгээр хүмүүстэй хамт байгаа юм.” гэв.

Есүс ингэж 12 шавиа дуудсан юм.

Харин шавь нар нь Есүстэй хамт гурван жилийн турш хамт байж багш болсон Есүсээс олон зүйлийг суралцсаар байв.

Мөн Есүсийг тэнгэр өөд явсны дараа шавь нар нь Есүсийн газар дээр хийж байсан ажлыг үргэлжлүүлэн хийж байлаа. Тэд бусдад зааж, Бурханы хаанчлалыг тунхаглаж, өвчтэй хүмүүсийг эдгээж байлаа.

- Дараах библийн эшлэлийг дуурайж бицээд цээжлээрэй. (Матай 4:19)

Би та нарыг хүмүүсийн загасчид
болгоно гэв.



Бүтээлч байцгаая 1. Доорх загасны дүрснүүдийг хайчилж усны зурган дээр наагаарай.



